



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

23119 Чингис хот, Хэнтий аймаг,
Утас/Факс: 70-56-24-12
E-mail: infoazdtg@khentii.gov.mn

БАЯНМӨНХ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

2022.05.03 № 7/967
танай _____-ны № _____-т

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 04 дугаар сарын 14-ны өдөр тус сумын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг хяналтад аваагүйн улмаас агентлагууд руу хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн биелэлт хугацаандаа явсан эсэх, ямар биелэлт яваад хэрхэн үнэлэгдэж байгааг мэддэггүй, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж эзэнжүүлээгүй. Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний уялдааг хангаж, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг зөв тодорхойлох, сумын Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан дахин төлөвлөх шаардлагатай гэж дүгнэж байна.

Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудасны хадгалалт, хамгаалалтын найдвартай байдал бүрэн хангагдаагүй. Албан хэргийн үйл ажиллагаанд бичиг хэргийн ажилтны хэрэглэх “Хуулбар үнэн, Байгууллагад баримт бичиг хүлээн авсан”, “Боловсруулсан, хянасан” дардасгүй. Хэвлэмэл хуудасны эхийг хянуулаагүй, хэвлэгч /принтер/-ээр хэвлэсэн стандартын бус хэвлэмэл хуудас ашиглаж байна. Хэвлэмэл хуудасны индекс батлаагүй, зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй.

Зөвлөмж:

1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтуудыг жил бүр жагсаалт гарган шинэчлэн батлуулж, агентлаг руу явуулах биелэлтэд хяналт тавьж ажиллах
2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг зөв тодорхойлох, шинээр орох төрийн жинхэнэ албан хаагчдад гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах чиглэлээр сургалт явуулж төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уялдуулан боловсруулах
3. Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах
4. Үйлчилгээний стандартаа тогтмол мөрдөж ажиллах
5. Үнэлгээний төхөөрөмжийн журмын хэрэгжилтийг хангаж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчээр үнэлүүлж, АХХ-ын журамд заасны дагуу шаардлага хангасан тайлан,

2.

мэдээг заасан хугацаанд үнэн бодитой гаргаж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэх

6. Удирдлагууд болон нийт албан хаагчид www.erp.e-mongolia.mn системийг тогтмол ашиглаж, удирдлагууд хяналт тавьж хэвших, босоо удирдлагатай албан хаагчдыг тухайн сумын ЗДТГ-т эрх үүсгэх, админ эрхтэй албан хаагч шинээр орсон ажилтан албан хаагчдыг системд бүртгэх, албан хаагчдын системд хандах эрхийг бүрэн гүйцэд, зөв тохируулах

7. Өргөдөл гомдлын бүртгэлийг оны эхнээс шинэ дэвтэр дээр эхлүүлэх

8. Сумын мэдээлэл хүргэдэг хуудсуудыг идэвхтэй ажиллуулж тогтмол мэдээлэл оруулдаг байх, аймгийн ЗДТГ-ын хуудсыг дагаж мэдээллийг сумын цахим хуудсуудаар хуваалцдаг байх

9. Орон нутгийн төсвийн байгууллагуудад санхүүжилтийн эрх олгох ЗЭБ-1 маягтын дутууг гүйцээж жагсаалтыг Засаг даргаар батлуулах, Төсөвт байгууллагын нягтлан бодогч солигдсон тухай бүрт зөвшилцлийн бичгийг тогтмол авч байх, Соёлын төв, сангууд хариуцсан нябо-н зөвшилцлийн бичгийг нөхөж авах.

10. Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор баталсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх хэрэглэх журам”, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Архивын ерөнхий газрын даргын 2016 оны А/142 дугаар тушаалаар баталсан “Хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх, хадгалах журам”, Монгол Улсын стандарт MNS 5140-2:2021 Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавигдах шаардлага, MNS 5140-3:2021 Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлийг байрлуулахад тавигдах шаардлагыг баримтлан ажиллах

Зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган биелэлтийг 2022 оны 05 сарын 13-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ГАНЧИМЭГ

